

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 2 сарын 25 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

ХААЛТТАЙ ХҮРЭЭНД ЭНГИЙН ХУВЬЦАА НЭМЖ ГАРГАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3, 38 дугаар зүйлийн 38.8, 42 дугаар зүйлийн 42.1, 55 дугаар зүйлийн 55.2, 55.3, 76 дугаар зүйлийн 76.1, 76.1.4, 76.1.6, 76.1.16, 87 дугаар зүйлийн 87.1.2 заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9.2.12.12, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх, зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор компанийн зарласан хувьцаанаас хаалттай хүрээнд энгийн хувьцаа нэмж гаргасугай.
2. Хаалттай хүрээнд нэмж гаргаж буй энгийн хувьцааны үнэ, тоо ширхэг, ерөнхий нөхцлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
3. Хаалттай хүрээнд энгийн хувьцаа нэмж гаргах үйл ажиллагааны хүрээнд холбогдох гэрээ байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Золжаргал)-д олгосугай.
4. Хаалттай хүрээнд энгийн хувьцаа нэмж гаргах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, уг асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэх, энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Золжаргал)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 2 сарын 25 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Хуулийн компани сонгох тухай

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.9 дахь заалтыг үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Компанийн хаалттай хүрээнд энгийн хувьцаа нэмж гаргахад хамтран ажиллах хуулийн байгууллагаар Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй “Өмгөөллийн Легал Полиси” ХХН-ийг сонгосугай.
2. “Өмгөөллийн Легал Полиси” ХХН -тай байгуулах гэрээний нөхцөлийг хэлэлцэн тохирох, гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Золжаргал)-д олгосугай.
3. Хуулийн байгууллагыг төлөвлөсөн хугацаанд ажиллах нөхцөл боломжоор хангаж, хамтарч ажиллах, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөх, шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Золжаргал/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч. Чинзориг

Ч.ЧИНЗОРИГ

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 2 сарын 25 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗУУЧЛАЛЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.2 болон 80 дугаар зүйлийн 80.7, 89 дүгээр зүйлийн 89.1.1 болон Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.19-д заасныг үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Япон улсаас хөрөнгө оруулалт татахтай холбогдуулан “Сикап ҮЦК” ХХК-тай “Хөрөнгө оруулалтын зуучлалын гэрээ” байгуулсугай.
2. Компанийг төлөөлөн “Хөрөнгө оруулалтын зуучлалын гэрээ” байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Золжаргал)-д олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч. Чинзориг

Ч.ЧИНЗОРИГ